

**"ОЛОН УЛСЫН АВТОТЭЭВРИЙН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ МОНГОЛ УЛС БОЛОН
БҮГД НАЙРАМДАХ СЛОВАК УЛС ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР"-ИЙН ТӨСЛИЙГ
ЗӨВШИЛЦСӨН ТАЛААРХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 06 дугаар
сарын 06-ны өдөр

Улаанбаатар
хот

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд зөвшилцөхөөр ирүүлсэн "Олон улсын автотээврийн харилцааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Словак Улс хоорондын хэлэлцээр"-ийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Уг төслийг Байнгын хороогоор хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлээгүй бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонх "Олон улсын автотээврийн харилцааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Словак Улс хоорондын хэлэлцээр"-ийн төслийг зөвшилцөх тухай асуудлыг дэмжсэн болно.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Б.ЭНХ-АМГАЛАН